

Гадаадын иргэд Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсны дагуу оршин сууж буй эсэхт шалгалт хийх журам, зарчмуудын талаар санамж

- Үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх хуулийн үндэслэл: 2013 оны арванхоёрдугаар сарын 12-ны өдөр батлагдсан Гадаадын иргэдийн тухай Хууль
- Авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго: Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд нэвтрэн орох болон оршин суух нөхцлүүдэд хамаарах хууль дүрмүүдийн даган мөрдөлтийг хянах.

Гадаадын иргэн нь Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух хугацаандаа, аяллын баримт бичиг болон Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух эрхийг түүнд олгосон бичиг баримтууд шаардагддаг тохиолдолд, тийм хүчин төгөлдөр баримт бичгүүдийг эзэмшсэн байх үүрэгтэй.

1. Ажилтан албан үнэмлэх, таних тэмдгээ үзүүлсний дараагаар:
 - 1) аяллын баримт бичиг болон Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух эрхийг гадаадын иргэнд олгосон бичиг баримтууд;
 - 2) зардлын мөнгө, үүнд:
 - а) гадаадын иргэн Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух хугацаанд хэрэглэх,
 - б) гадаадын иргэн эх орон руугаа эсвэл өөрийн оршин суудаг улс орон руу буцах,
 - в) гадаадын иргэн өөрт нь орох зөвшөөрөл олгох гуравдагч орныг зорьж, Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд гарах зардлын мөнгө;
 - 3) мөнгө олох боломжтой болохыг гэрчилсэн бичиг баримт;
 - 4) хөдөлмөр эрхлэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах эсвэл хөдөлмөр эрхлүүлэх эрх олгосон баримт бичгүүд;
 - 5) Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух зорилго болон нөхцлүүдийг баталсан бичиг баримтуудыг үзүүлэхийг шаардах эрхтэй.
2. Таныг шалгах тохиолдолд, шаардлагатай үед, дээр дурдсан бичиг баримтууд болон мөнгө эсвэл мөнгөтэй болох боломжтой болохыг гэрчилсэн бичиг баримтуудыг Та ажилтны шаардлагаар үзүүлэх үүрэгтэй.
3. Хэрэв Та өөрийг тань хэн болохыг баталсан ямар ч бичиг баримтгүй байсан тохиолдолд, Таны хэн болохыг тогтоох зорилгоор Танаас хурууны хээ авна.

Мөнтүүнчлэн Шенгений виз жинхэнэ эсэхийг шалгах мөн тийм виз эзэмшигчийн хэн болохыг шалгах зорилгоор хурууны хээг авч болно.

Гадаадын иргэдээс авсан хурууны хээг Визийн Мэдээллийн Системд шалгадаг.

4. Шалгалтын явцад, олгосон байгууллагад буцааж өгөх үүрэгтэй байсан бичиг баримтыг Та хэрэглэж байгаа тань илэрсэн тохиолдолд, уг бичиг баримтыг хурааж авна. Ингэсэн тохиолдолд, бичиг баримтаа хураалгуулсан тухай тодорхойлолтыг Танд үнэ төлбөргүйгээр олгох ба харин хурааж авсан бичиг баримтыг түүнийг олгосон байгууллагад илгээнэ.
5. Шалгалт явуулсны дараагаар, Та хууль бусаар оршин сууж байгаа болох нь тогтоогдсон тохиолдолд, Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн хууль ёсны дагуу оршин сууж буй эсэхт хийсэн шалгалтын протокол үйлдэнэ.

6. Протоколын эх хувийг Танаар гарын үсэг зуруулахаар өгнө. Ингэсний дараагаар Танд түүний хуулбарыг олгоно.

Та протоколд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд, уг протоколыг үйлдсэн ажилтан түүнд өөрөө гарын үсгээ зурж, хуулбарыг Танд үлдээнэ.

7. Дараах тохиолдлуудад:

- 1) Та тийм хуулийн эрхгүй мөртлөө Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа,
- 2) Танд Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух эрх олгосон бичиг баримтууд шаардагдах тохиолдолд, тийм бичиг баримт үзүүлэхийг эрх бүхий байгууллагаас шаардахад Та үзүүлэхгүй байх,
- 3) хэрэгцээний мөнгө эсвэл тийм мөнгөтэй болох боломжтой болохыг баталсан бичиг баримт үзүүлэхийг эрх бүхий байгууллагаас шаардахад Та үзүүлэхгүй байх,
- 4) оршин суух карт, гадаадын иргэдэд зориулагдсан польшийн аяллын баримт бичиг, гадаадын иргэний хэн болохыг гэрчилсэн польшийн бичиг баримт эсвэл “оршин суухыг хүлчин тэвчих зөвшөөрлөө” солиулах буюу буцааж өгөх үүргээ биелүүлэхээс Та зайлсхийж байгаа,
- 5) Та оршин суух карт, гадаадын иргэдэд зориулагдсан польшийн аяллын баримт бичиг, гадаадын иргэний хэн болохыг гэрчилсэн польшийн бичиг баримт эсвэл “оршин суухыг хүлчин тэвчих зөвшөөрлөө” хаяж гээгдүүлсэн талаар тэдгээрийг хаяж гээгдүүлснээс хойш 3 хоногийн дотор мэдэгдээгүй,
- 6) Та Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэрээс гарч явах үүргээ, Таныг буцаж явахыг үүрэг болгох тухай шийдвэрт эс бөгөөс сайн дураараа буцах хугацааг сунгах тухай шийдвэрт тодорхойлогдсон хугацаанд багтаж гүйцэтгээгүй,
- 7) сайн дураараа буцах хугацааг сунгах тухай шийдвэрт дурдагдсан албан байгууллагад тодорхой цаг хугацаанд очих үүргээ Та биелүүлэхгүй байгаа,
- 8) сайн дураар буцах хугацааг сунгах тухай шийдвэрт тодорхойлогдсон оршин суух газрыг Та орхиж явсан,
- 9) Та хилийн бага хөдөлгөөний хүрээнд олгосон хилээр нэвтрэх зөвөөрөлд үндэслэн Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн ба:
 - а) ийм зөвшөөрөл эзэмшигч зорчих эрх бүхий хил орчмын бүс нутгаас Та гарч явсан буюу эсвэл,
 - б) уг зөвшөөрөлд тодорхойлогдсон оршин суух хугацаа дууссаны дараагаар Та Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэрээс гарч яваагүй тохиолдлуудад

- Танд торгууль ногдуулж болно.

Торгуулийн мөнгийг торгууль ногдуулсан ажилтанд шууд төлж болох ба тэгсэн тохиолдолд торгуулиар шийтгүүлэгч этгээдэд торгуулийн мандат олгоно. Торгуулийг шууд төлөх тохиолдолд, торгуулийн хэмжээ 500 злотоос үл хэтэрнэ.

Та торгуулийн мандатыг хүлээж авахаас татгалзах эрхтэй. Татгалзсан тохиолдолд, Танд шийтгэл ногдуулахыг хүссэн өргөдлийг шүүхэд илгээх ба шүүхээс 5000 хүртэл злотын торгууль ногдуулж болно.

Ажилтан мөнтүүнчлэн таны үйлдсэн дээр тодорхойлсноос бусад зөрчилтэй холбогдуулж Танд торгууль ногдуулж болно.

8. Бүгд Найрамдах Польш Улсын нутаг дэвсгэр дээр Та хууль ёсны дагуу оршин сууж буй эсэхт хийсэн шалгалтын протокол үйлдэх нь Таныг баривчлах мөн буцаж явах үүргийг Танд хүлээлгэх асуудлаар үйл ажиллагаа явуулж эхлүүлэх үндэслэл болж өгч болно.